



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар

1/99

Улаанбаатар хот

Инженер, техникийн ажилтны албан тушаалын ангилал,
зэрэглэл, үндсэн цалингийн сүлжээ болон тэдгээрт
мэргэшлийн зэрэг олгох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх,
дүгнэх журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.5, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.11 дэх заалт, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 732 дугаартай “МИАТ ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн инженер, техникийн ажилтнуудын цалин хөлсний бүтцийг оновчтой болгох, мэргэшлийн зэргийг агаарын хөлөг, түүний эд ангийн засвар үйлчилгээнд чиглүүлж ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох зорилгоор Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүдийн “Инженер, техникийн ажилтнуудын албан тушаалын ангилал, зэрэглэл, үндсэн цалингийн сүлжээ”-г 1 дүгээр хавсралтаар, “Инженер, техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Инженер, техникийн ажилтнуудын ажлын гүйцэтгэл /KPI/-ийг үнэлэх, дүгнэх журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. “Инженер, техникийн ажилтнуудын албан тушаалын ангилал, зэрэглэл, үндсэн цалингийн сүлжээ” шинэчлэн батлагдсантай холбогдуулан Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүдийн инженер, техникийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, тушаал, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын захирал /Э.Мөнхмарал/-д даалгасугай.

3. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүдийн инженер, техникийн ажилтнуудыг хөдөлмөрийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн дагуу цалинжуулж, мэргэшлийн зэргийн болон ажлын гүйцэтгэлийн нэмэгдлийг батлагдсан журмын дагуу тооцон олгохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Д.Даваадорж/-д зөвшөөрсүгэй.

4. Шинэчлэн батлагдсан “Инженер, техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох журам”-ын дагуу компанийн инженер, техникийн ажлын хэрэгцээ, шаардлагад үндэслэн 6 сар тутам мэргэшлийн зэргийн жагсаалтыг шинэчлэн батлуулах ажлыг хариуцан зохион байгуулж ажиллахыг Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ерөнхий менежер /С.Батмөнх/-т үүрэг болгосугай.

5. Шинээр батлагдсан “Инженер, техникийн ажилтнуудын ажлын гүйцэтгэл /KPI/-ийг үнэлэх, дүгнэх журам”-ыг хэрэгжүүлж харьяа нэгжүүдийнхээ ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтлан үр дүнд үндэслэн дүгнэж ажиллах, цаашид ажлын гүйцэтгэлийн үнэлгээний процессыг цахимжуулахыг Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ерөнхий менежер /С.Батмөнх/-т үүрэг болгосугай.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэрлэлийн газрын захирал бөгөөд Ерөнхий нисгэгч /Б.Гантулга/, Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын албаны дарга /Д.Цогтгэрэл/-д тус тус даалгасугай.

7.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/327 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "МИАТ" ТӨХК-ийн ажил, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтын Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүдэд хамаарах хэсэг, 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/327 тоот тушаалаар батлагдсан "МИАТ" ТӨХК-ийн албан тушаалын үндсэн цалингийн сүлжээ, жишгийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүдэд хамаарах хэсэг, 2023 оны 11 дүгээр сарын А/383 тоот тушаалаар батлагдсан "Инженер, техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох журам"-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХТАМИР



АГААРЫН ХӨЛГИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ХАРЬЯА ХЭЛТСҮҮДИЙН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДАД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

1.1.Ерөнхий зүйл

1.1.1.Энэхүү журам нь “МИАТ” ТӨХК-ийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтэс /цаашид “АХЗҮЕМХХ” гэх/-ийн инженер, техникийн ажилтан /цаашид “ИТА” гэх/-д агаарын хөлөг, түүний эд анги дээр ажиллах эрх бүхий мэргэшлийн зэрэг олгох, бууруулах, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Зорилго

1.2.1.Нислэгийн аюулгүй байдлыг хангах мэргэшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай ИТА бэлтгэж үйлдвэрлэлд ажиллуулах, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэн тогтвор суурьшилтай ажиллуулах, ИТА-ныг мэргэжлээрээ ажиллах, ур чадвараа ахиулах хүсэл эрмэлзэлтэй болгох, улмаар үйл ажиллагааг өргөжүүлэн ИТА-ны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.3.Хамрах хүрээ

1.3.1.Агаарын хөлөг болон түүний эд ангийн нислэгт тэнцэх чадвар /цаашид “НТЧ” гэх/-ыг хадгалах үйл ажиллагаатай холбоотой хийж буй агаарын хөлөг болон түүний эд ангийн техник үйлчилгээ, засвар, инженеринг, үйлдвэрлэл төлөвлөлт, хяналт, сэлбэг ханган нийлүүлэлт, чанар баталгаажуулалт, аюулгүй ажиллагаанд хяналт тавин ажиллаж буй ажлын цар хүрээгээр хязгаарлагдана.

ХОЁР. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Мэргэшлийн зэрэг олгох

2.1.1.Техникийн үйлчилгээний байгууллагын заавар /МОЕ, ММЕ/-т заасан Мэргэшлийн зэрэг олгох комисс /Qualification approval board/-ыг 6 сар тутам хуралдуулж мэргэшлийн зэрэг олгох, бууруулах, цуцлах ажлыг гүйцэтгэнэ.

2.1.2.Мэргэшлийн зэрэг олгох комисс /цаашид “Комисс” гэх/ нь мэргэшлийн зэрэгтэй ИТА-ны нэрсийн жагсаалтыг тухай бүрд нь шинэчлэн гаргах ба комисс дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн газрын захирал бөгөөд ерөнхий нисгэгч;
- Захиргаа, удирдлагын газрын захирал;
- Санхүү удирдлагын газрын захирал;
- Ерөнхий нягтлан бодогч;
- Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежер;

- Аюулгүй ажиллагаа, чанар, нислэгийн аюулгүй байдлын алба /цаашид "ААЧНАБА" гэх-ны дарга;
- Агаарын хөлгийн техник үйлчилгээний хэлтсийн дарга;
- Агаарын хөлгийн техникийн үйлдвэрлэл төлөвлөлт, хяналтын хэлтэс /цаашид "АХТҮТХХ" гэх/-ийн дарга;
- Агаарын хөлгийн инженерингийн хэлтсийн дарга;
- Агаарын хөлгийн техникийн хангамжийн хэлтсийн дарга;
- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга;
- ААЧНАБА-ны чанар баталгаажуулалтын менежер-инженер.

Нарийн бичгийн дарга:

- АХЗҮ-ний Ерөнхий менежерийн харьяа АХТҮТХХ-ийн Ахлах инженер.

2.1.3.Комиссын хурал даргалагчийг Комиссын хурал бүрт нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. Комиссын хурлыг 80-аас доошгүй хувийн ирцтэйгээр явуулна.

2.1.4.АХТҮТХХ нь компанийн нислэг үйлдвэрлэл, техник үйлчилгээний ажлын хэрэгцээ шаардлагад тулгуурлаж шаардлагатай мэргэшлийн зэрэгтэй ажилтны тоог мэргэшлийн зэргийн ангилал тус бүрээр гарган Комиссын хуралд танилцуулна.

2.1.5.Комиссоос гаргасан мэргэшлийн зэрэгтэй ИТА-ны нэрсийн жагсаалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

2.1.6.Комиссыг шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хуралдуулж болно.

2.1.7.АХЗҮ-ний Ерөнхий менежер, ААЧНАБА-ны дарга болон тус албаны Чанар баталгаажуулалтын менежер-инженер Комиссын хуралд заавал оролцоно. Комиссын гишүүн, нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх шалтгаан /томилолтоор явсан, өвчтэй, захиргааны чөлөөтэй байгаа/-аар хуралд оролцох боломжгүй тохиолдолд тухайн албан тушаалтныг албан ёсоор орлон ажиллаж буй албан тушаалтныг хуралд оролцуулна.

2.1.8.Комиссын нарийн бичгийн дарга нь хуралд саналын эрхтэй оролцох ба хурал зарлах, гишүүдийг мэдээллээр хангах, хурлын тэмдэглэл, баримт бичиг хөтлөх, архивлах зэрэг зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

2.1.9.Комиссын хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар комиссын шийдвэр албажна. Хэрэв гишүүн хурлын шийдвэртэй санал нийлээгүй тохиолдолд шалтгаанаа хурлын тэмдэглэлд тусгуулж гарын үсэг зурж баталгаажуулна.

2.1.10.Комиссын гишүүний мэргэшлийн зэргийг хэлэлцэх тохиолдолд тус гишүүн өөрт холбоотой хэлэлцүүлэгт санал өгөхөөс түдгэлзэнэ.

2.1.11.ИТА нь компаниас томилсон сургалт, дадлагад хамрагдах зорилгоор техник үйлчилгээ, засварын ажилд 3 сар болон түүнээс дээш хугацаагаар оролцоогүй тохиолдолд түүнд зэргийн нэмэгдэл олгохгүй.

2.1.12.Агаарын хөлгийн засвар, үйлчилгээний ажлын ачаалал, хэрэгцээнээс шалтгаалан мэргэшлийн зэргийн ажилд 3 сар оролцоогүй ИТА-ныг АХЗҮ-ний Ерөнхий менежер нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэст дараа улирлын эхний 7 хоногт багтаан албан бичгээр мэдэгдэн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 1 улирлын хугацаагаар зогсооно.

2.2. Мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлага

2.2.1. Агаарын хөлөг, түүний эд ангийн мэргэшлийн зэрэг горилогч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

а) Т, Аг зэрэг горилогч нь ТҮБ-ийн заавар /МОЕ, ММЕ/-т заасан шаардлагуудыг бүрэн хангасан байна;

б) А, В1, В2, Вг, С зэрэг горилогч нь ТҮБ-ийн заавар /МОЕ, ММЕ/-т заасан шаардлагуудыг бүрэн хангасан байна;

в) Аливаа зэрэг горилогч нь 2 улирлын ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ нь 81% ба түүнээс дээш үзүүлэлтээр хангасан байна.

ГУРАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ТОГТООЖ ОЛГОХ

3.1. ИТА-ны мэргэшлийн зэрэг нь гүйцэтгэх ажлын цар хүрээ, тавигдах шаардлагаар (1) Т, (2) Аг, А, (3) В1/В2/Вг, (4) С гэсэн дөрвөн шатлалтай байна.

3.1.1. Т, А, В1, В2, С зэргүүд нь агаарын хөлгийн техник үйлчилгээ, засвар, хөдөлгүүр асаалт, НТЧ баримт бичиг боловсруулах, инженеринг, сэлбэг ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл төлөвлөлт, хяналт, аюулгүй ажиллагааны аудитын ажилтнуудад хамаарна.

3.1.2. Аг, Вг зэргүүд нь агаарын хөлгийн эд ангийн техник үйлчилгээ, засвар, дурангийн үзлэг /borescope inspection/, бүтцийн засвар /structure/, үл эвдэх сорил /NDI/, эд анги үйлдвэрлэл /Part Fabrication зэрэг ажлууд тус тус хамаарна.

3.2. ИТА-ны мэргэшлийн зэргийн нэмэгдлийн үнэлгээг доорх хүснэгтэд заасан хувиар тооцно.

№	Зэрэг	Олгох хувь	Тайлбар
1	"Т"	25	Үндсэн цалингийн сүлжээний механикч /Е5/-ийн 1-р дэвийн доод түвшинөөс
2	"А, Аг"	25	Үндсэн цалингийн сүлжээний техникч /Е4/-ийн 1-р дэвийн доод түвшинөөс
3	"В1, В2, Вг"	30	Үндсэн цалингийн сүлжээний инженер /Е3/-ийн 1-р дэвийн доод түвшинөөс
4	"С"	30	Үндсэн цалингийн сүлжээний Ахлах инженер /Е2/-ийн 1-р дэвийн доод түвшинөөс

Жишээлбэл: Ахлах инженер "1 төрлийн В1, 2 төрлийн А" зэрэгтэй гэж үзвэл зэргийн нэмэгдлийг дараах жишээний дагуу бодно.

$Y1 + Y2 * N + Y3 =$ Нийт зэргийн нэмэгдэл.

- I зэрэг $Y1 = \text{В1 зэргийн } /3'000'000 \text{ төг} / * 30\% * 1$
- II, III зэрэг $Y2 = \text{А зэргийн } /1'810'000 \text{ төг} / * 25\% * 2$

$3'000'000 \text{ төг} * 30\% + 1'810'000 \text{ төг} * 25\% * 2 = 1,805,000 \text{ төгрөг}.$

Нийт зэргийн нэмэгдэлд 1'805'000 төгрөг олгоно.

3.3. ИТА нь 3-аас дээш мэргэшлийн зэрэгтэй бол зэргийн нэмэгдлийг тооцохдоо 4 дэх зэргээс нь эхлэн зэргийн нэмэгдлийн хувийг 3.2-т заасан хувиас тус бүр 10 хувиар бууруулж тооцно.

Тайлбар: Зэргийн нэмэгдлийг тооцохдоо "C", "B1", "B2", "Br", "A", "Ar", "T" гэсэн дарааллаар хамгийн өндөр зэргээс эхэлж тооцох зарчмыг баримтална.

Жишээлбэл: Ахлах инженер "2 төрлийн B1 /Y1/, 2 төрлийн A /Y2/, 1 төрлийн Ar /Y3/" зэрэгтэй гэж үзвэл зэргийн нэмэгдлийг дараах жишээний дагуу бодно.

$Y1 * M + Y2 * N + Y3 =$ Нийт зэргийн нэмэгдэл

- | | |
|---------------|---|
| - I, II зэрэг | $Y1 = B1 \text{ зэргийн } /3'000'000 \text{ төг/} * 30\% * 2$ |
| - III зэрэг | $Y2 = A \text{ зэргийн } /1'810'000 \text{ төг/} * 25\% * 1$ |
| - IV, V зэрэг | $Y3 = A/Ar \text{ зэргийн } /1'810'000 \text{ төг/} * 15\% * 2$ |

$3'000'000 \text{ төг} * 30\% * 2 + 1'810'000 \text{ төг} * 25\% + 1'810'000 \text{ төг} * 15\% * 2 = 2,795,500 \text{ төгрөг.}$

Нийт зэргийн нэмэгдэл нь 2'795'500 төгрөг олгоно.

3.4. Мэргэшлийн зэргийг бууруулах, цуцлах

3.4.1. Дараах тохиолдолд Комиссын хурлаар хэлэлцүүлэн мэргэшлийн зэргийг бууруулах, бууруулсан шаардлагыг хангахгүй тохиолдолд цуцлах шийдвэр гаргана.

- Энэ журам болон ТҮБ-ийн заавар /МОЕ, ММЕ/-т заасан шаардлагуудыг хангахааргүй болсон;
- Мэргэшлийн алдаа дутагдал гаргасныг эрх бүхий байгууллага тогтоосон;
- Тухайн мэргэшлийн зэрэг хэрэгцээ шаардлагагүй болсон.

3.5. Маргаан шийдвэрлэх

3.5.1. Мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой Комиссын хурлын гаргасан шийдвэрт хурлын нарийн бичгийн даргаар уламжлан Захиргаа, хүний нөөцийн хэлтэст гомдол гаргаж болно.

“МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025
оны 02 дүгээр сарын 28-ны өдрийн 199
дугаар тушаалын 3-р хавсралт



**“МИАТ” ТӨХК-ИЙН АГААРЫН ХӨЛГИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕРИЙН ХАРЬЯА ХЭЛТСҮҮДИЙН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ /КР/-ИЙГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “МИАТ” ТӨХК /цаашид “Компани” гэх/-ийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний Ерөнхий менежерийн харьяа хэлтсүүд /цаашид “АХЗҮЕМХХ” гэх/-ийн инженер, техникийн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх болон гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохтой холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Компанийн нислэг-үйлдвэрлэл, аюулгүй ажиллагаа, агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварыг хангахтай холбоотой инженеринг, засвар үйлчилгээ, төлөвлөлт, сэлбэг хангамжийн үүрэг гүйцэтгэж байгаа АХЗҮЕМХХ-ийн инженер, техникийн ажилтнуудад /цаашид “ИТА” гэх/ энэхүү журам хамаарна.
- 1.3. АХЗҮЕМХХ-ийн ИТА-ны ажлын гүйцэтгэлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан жишиг үнэлгээний хуудас болон хэлтэс, нэгжийн ажлын үндсэн чиг үүрэгтэй уялдсан шалгуур үзүүлэлтээр улирал бүр үнэлж дүгнэнэ.
- 1.4. АХЗҮЕМХХ-ийн ИТА-ны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх, гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохтой холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална.
 - 1.4.1. шударга байх;
 - 1.4.2. үнэлгээ ил тод, нээлттэй байх;
 - 1.4.3. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
 - 1.4.4. зөвхөн бодит гүйцэтгэл, үр дүнд үндэслэх.
- 1.5. Энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу АХЗҮЕМХХ-ийн ИТА-ны гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ.

**ХОЁР. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛД
СУУРИЛСАН НЭМЭГДЭЛ ОЛГОХ**

- 2.1. АХЗҮЕМХХ-ийн ИТА-ны ажлын гүйцэтгэлийг 0-100 хүртэлх онооны системийг ашиглан үнэлнэ.
- 2.2. ИТА-ны ажлын гүйцэтгэлийг улирал бүр үнэлэх бөгөөд доорх хүснэгтэд заасан хэмжээгээр нэмэгдэл олгоно.

№	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний оноо /улирлаар/	Улиралд 1 удаа олгох нэмэгдэл /үндсэн цалингийн хувь/	Гүйцэтгэлийн нэмэгдлийг дараа улирлын эхний сарын цалин дээр нэмж олгоно.
1.	96 ба түүнээс дээш оноо авсан бол	15 хувь	
2.	91-95 оноо авсан бол	10 хувь	
3.	81-90 оноо авсан бол	5 хувь	

- 2.3. Энэхүү журмын 2.2-т заасан ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 60-80 оноо авсан ИТА-д ажлын гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгохгүй.
- 2.4. Тухайн ИТА-ны бүтэн жилийн үнэлгээний дундаж 81 ба түүнээс дээш оноогоор үнэлэгдсэн тохиолдолд үндсэн цалингийн дэвийг 1 шатаар ахиулах үндэслэл болно.
- 2.5. Улирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр 59 буюу түүнээс доош оноо авсан ажилтныг үндсэн ажил, үүргээ хангалтгүй гүйцэтгэсэнд тооцож, ажлын гүйцэтгэлээ сайжруулах 3 сарын хугацаа олгоно. Хэрвээ уг хугацаанд ажлын гүйцэтгэлээ сайжруулаагүй тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.
- 2.6. Гүйцэтгэх захирлын тушаалаар хөдөлмөрийн сахилгын шийтгэл хүлээсэн ИТА-нд сахилгын шийтгэлтэй байх хугацаанд гүйцэтгэлийн үр дүнгийн нэмэгдэл олгохгүй.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 3.1. Энэхүү журамд заасан гүйцэтгэлийн нэмэгдэл олгох, сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийг Гүйцэтгэх захирлын тушаалаар албажуулна.
- 3.2. Энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргуулах талаар АХЗҮ-ний Ерөнхий менежер холбогдох үндэслэл бүхий саналаа үнэлгээний хуудсын хамт Захиргаа, хүний нөөцийн хэлтэст ирүүлэх бөгөөд тус хэлтэст ирүүлсэн саналыг нягталж, үндэслэлтэй гэж үзвэл Гүйцэтгэх захиралд танилцуулж, тушаалаар албажуулж, СНББХ-ийн цалин хөлсний нягтлан бодогчид шилжүүлнэ.
- 3.3. ИТА нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой гомдлоо тухайн улирлын үнэлгээ гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор АХЗҮ-ний Ерөнхий менежерт гаргах эрхтэй бөгөөд Ерөнхий менежерийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ажлын 3 хоногт багтаан Захиргаа, хүний нөөцийн хэлтэст гомдол гаргах эрхтэй.
- 3.4. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

“МИАТ” ТӨХК-ийн АХЗҮЕМХХ-ийн Инженер
техникийн ажилтны ажлын гүйцэтгэл /КРП/-ийг
үнэлэх, дүгнэх журмын хавсралт 1



Агаарын хөлгийн техникийн үйлдвэрлэл төлөвлөлт, хяналтын хэлтсийн
инженер, техникийн ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүн /КРП/-г
үнэлэх үнэлгээний жишиг хуудас

АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ				
Овог, нэр:				
Албан тушаал:				
НЭГ. ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ				
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал	Үнэлгээний Нийт оноо
1	2	3	4	5
		50 оноо	10 оноо	60 оноо
ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ (10-аас багагүй ажлаар үнэлнэ.)				
1	Scheduled Maintenance Compliance			
2	Aircraft Availability			
3	Turnaround Time (TAT) for Maintenance			
4	Line Maintenance Planning Accuracy			
5	Cost Efficiency of Maintenance			
6	Maintenance Backlog			
7	Parts Availability for Scheduled Maintenance			
8	Man Power Planning			
9	Weekly Master Maintenance Plan update			
10	Component Contracted Maintenance schedule			
Дундаж оноо				
ХОЁР. УДИРДЛАГА, ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ				
№	Үзүүлэлт	Үнэлгээ нийт (15 оноо)		
1	2	3		
1	Харилцаа, хандлага, ёс зүй			
2	Баг, хамтын ажиллагаа			
3	Олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцдог эсэх			
4	Хариуцлага хүлээх			
5	Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент			
6	Төлөвлөх, зохион байгуулах			
7	Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох			
8	Дүн шинжилгээ хийх			
Дундаж оноо				

ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (3-аас багагүй ажлаар үнэлнэ.)	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Үнэлэх үзүүлэлт 1	
2	Үнэлэх үзүүлэлт 2	
3	Үнэлэх үзүүлэлт 3	
Дундаж оноо		
ДӨРӨВ. ААЧНАБА-ны ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (доорх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн үнэлгээний 10 онооноос хасч үнэлнэ.)	Үнэлгээ нийт (10 оноо)
1	2	3
1	ААЧНАБА-ны дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд засаж залруулаагүй бол.	
2	Заавар, дүрэм журмыг зөрчсөн бол.	
Дундаж оноо		
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		
1	Үндсэн ажлын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (60 хүртэлх оноо)	
2	Удирдлага, хамт олны үнэлгээ (15 хүртэлх оноо)	
3	Ур чадвар болон нэмэлт ажлын үнэлгээ (15 хүртэлх оноо)	
4	ААЧНАБА (10 хүртэлх оноо)	
Нийт үнэлгээ		

Ерөнхий үнэлгээ:	- 96 – 100 оноотой бол “А+ буюу Шилдэг” - 91 – 95 оноотой бол “А буюу Маш сайн” - 81 – 90 оноотой бол “В буюу Сайн” - 60 – 80 оноотой бол “С буюу Хангалттай” - 59 онооноос доош бол “F буюу Хангалтгүй”.
Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урамшуулах, хариуцлага тооцох гэх мэт. /-ний санал: Нэгжийн даргын тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гэх мэт. /:	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Үнэлгээтэй танилцсан:

Ажилтан

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Хянасан:

АХЗҮ-ний Ерөнхий менежер

(гарын үсэг)

.....(огноо)

**Агаарын хөлгийн Инженерингийн хэлтсийн инженер, техникийн ажилтны
ажлын гүйцэтгэлийн үр дүн /KPI/-г үнэлэх үнэлгээний жишиг хуудас**

АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ				
Овог, нэр:				
Албан тушаал:				
НЭГ. ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ				
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо
1	2	3	4	5
		50 оноо	10 оноо	60 оноо
ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ (10-аас багагүй ажлаар үнэлнэ.)				
1	Хариуцсан систем (ATA) дээрх нислэгт тэнцэх чадварын удирдамжийн хяналт (AD handling)			
2	Хариуцсан систем (ATA) дээр гарсан сервис бюллетин (SB) хяналт (SB handling)			
3	Хариуцсан систем (ATA) ажлын зааварчилгааг боловсруулах (TC) бэлтгэх			
4	Хамгийн бага нисч болох тоноглолын жагсаалтыг агуулсан баримт бичгийг боловсруулсан байдал (MEL Development)			
5	Landing Gear LLP control Хөл ангийн хатуу цагт эд ангийн жагсаалтын хяналт			
6	Maintenance Data Техник үйлчилгээнд ашиглагдах баримт бичгийн хяналт			
7	AMP development Агаарын хөлөг түүний эд ангийн засварын үечлэлийн хяналтын баримт бичиг боловсруулалт			
8	Technical Record Техникийн бичиг баримт хадгалалт			
9	Modification status Агаарын хөлөг түүний эд анги өөрчлөлт сайжруулалтын хяналт			
10	Reliability Агаарын хөлгийн найдвартай ажиллагааны хяналт			
Дундаж оноо				
ХОЁР. УДИРДЛАГА, ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ				
№	Үзүүлэлт	Үнэлгээ нийт (15 оноо)		
1	2	3		
1	Харилцаа, хандлага, ёс зүй			
2	Баг, хамтын ажиллагаа			
3	Олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцдог эсэх			
4	Хариуцлага хүлээх			
5	Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент			
6	Төлөвлөх, зохион байгуулах			
7	Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох			
8	Дүн шинжилгээ хийх			
Дундаж оноо				

ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (3-аас багагүй ажлаар үнэлнэ.)	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Үнэлэх үзүүлэлт 1	
2	Үнэлэх үзүүлэлт 2	
3	Үнэлэх үзүүлэлт 3	
Дундаж оноо		
ДӨРӨВ. ААЧНАБА-ны ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (доорх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн үнэлгээний 10 онооноос хасч үнэлнэ.)	Үнэлгээ нийт (10 оноо)
1	2	3
1	ААЧНАБА-ын дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд засаж залруулаагүй бол.	
2	Заавар, дүрэм журмыг зөрчсөн бол.	
Дундаж оноо		
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		
1	Үндсэн ажлын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (60 хүртэлх оноо)	
2	Удирдлага, хамт олны үнэлгээ (15 хүртэлх оноо)	
3	Ур чадвар болон нэмэлт ажлын үнэлгээ (15 хүртэлх оноо)	
4	ААЧНАБА (10 хүртэлх оноо)	
Нийт үнэлгээ		

Ерөнхий үнэлгээ:	- 96 – 100 оноотой бол “А+ буюу Шилдэг” - 91 – 95 оноотой бол “А буюу Маш сайн” - 81 – 90 оноотой бол “В буюу Сайн” - 60 – 80 оноотой бол “С буюу Хангалттай” - 59 онооноос доош бол “F буюу Хангалтгүй”.
Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урамшуулах, хариуцлага тооцох гэх мэт. /-ний санал:	
Нэгжийн даргын тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гэх мэт. /:	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Үнэлгээтэй танилцсан:

Ажилтан

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Хянасан:

АХЗҮ-ний Ерөнхий менежер

(гарын үсэг)

.....(огноо)

Агаарын хөлгийн Техникийн хангамжийн хэлтсийн инженер, техникийн ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүн /KPI/-г үнэлэх үнэлгээний жишиг хуудас

АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ				
Овог, нэр:				
Албан тушаал:				
НЭГ. ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ				
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо
1	2	3	4	5
		50 оноо	10 оноо	60 оноо
ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ (10-аас багагүй ажлаар үнэлнэ.)				
1	PO, EX, LO, RO үүсгэж захиалга хийх			
2	AOG болсон үед сэлбэг, эд ангийг хурдан шуурхай олж захиалга хийх			
3	Хурдан шуурхай тээвэрлэлт хийх			
4	Үүсгэсэн захиалгуудтай холбоотой төлбөр тооцоог хянах			
5	Агуулахад ирсэн сэлбэг, эд анги, багаж тоног төхөөрөмжийг хүлээж авах, байрлуулах, бүрэн бүтэн байдлыг хянах			
6	Calibration хийх шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг хянаж, цаг хугацаанд нь calibration-д явуулах			
7	Агуулахын эмх цэгцтэй байдлыг хангах			
8	Агаарын хөлгөөс буусан эд ангийг буцаах ажлыг зохион байгуулах			
9	Засварт явуулах шаардлагатай сэлбэг, эд анги, тоног төхөөрөмжийг засварт явуулах			
10	Импорт болон экспортын гаалийн бүрдүүлэлтийг хийх			
11	Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх			
12	Техник үйлчилгээнд ашиглагдах сэлбэг, эд ангийн судалгаа хийж агуулахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх			
Дундаж оноо				
ХОЁР. УДИРДЛАГА, ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ				
№	Үзүүлэлт	Үнэлгээ нийт (15 оноо)		
1	2	3		
1	Харилцаа, хандлага, ёс зүй			
2	Баг, хамтын ажиллагаа			
3	Олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцдог эсэх			
4	Хариуцлага хүлээх			
5	Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент			
6	Төлөвлөх, зохион байгуулах			
7	Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох			
8	Дүн шинжилгээ хийх			

Дундаж оноо		
ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (3-аас багагүй ажлаар үнэлнэ.)	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Үнэлэх үзүүлэлт 1	
2	Үнэлэх үзүүлэлт 2	
3	Үнэлэх үзүүлэлт 3	
Дундаж оноо		
ДӨРӨВ. ААЧНАБА-НЫ ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (доорх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн үнэлгээний 10 онооноос хасч үнэлнэ.)	Үнэлгээ нийт (10 оноо)
1	2	3
1	ААЧНАБА-ын дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд засаж залруулаагүй бол.	
2	Заавар, дүрэм журмыг бол.	
Дундаж оноо		
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		
1	Үндсэн ажлын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (60 хүртэлх оноо)	
2	Удирдлага, хамт олны үнэлгээ (15 хүртэлх оноо)	
3	Ур чадвар болон нэмэлт ажлын үнэлгээ (15 хүртэлх оноо)	
4	ААЧНАБА (10 хүртэлх оноо)	
Нийт үнэлгээ		

Ерөнхий үнэлгээ:	- 96 – 100 оноотой бол "А+ буюу Шилдэг" - 91 – 95 оноотой бол "А буюу Маш сайн" - 81 – 90 оноотой бол "В буюу Сайн" - 60 – 80 оноотой бол "С буюу Хангалттай" - 59 онооноос доош бол "F буюу Хангалтгүй".
Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урамшуулах, хариуцлага тооцох гэх мэт. /-ний санал: Нэгжийн даргын тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гэх мэт. /:	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Үнэлгээтэй танилцсан:

Ажилтан

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Хянасан:

АХЗҮ-ний Ерөнхий менежер

(гарын үсэг)

.....(огноо)

Агаарын хөлгийн Техник үйлчилгээний хэлтсийн инженер, техникийн ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүн /KPI/-г үнэлэх үнэлгээний жишиг хуудас

АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ				
Овог, нэр:				
Албан тушаал:				
НЭГ. ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ				
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо
1	2	3	4	5
		50 оноо	10 оноо	60 оноо
ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ (10-аас багагүй ажлаар үнэлнэ)				
1	Агаарын хөлгийн гарсан дутагдалыг цаг алдахгүй зөв тодорхойлон шийдвэр гаргах			
2	Агаарын хөлгийн техник үйлчилгээний заавар, ажлын наряд бүрэн гүйцэт ойлгож гүйцэтгэх			
3	Агаарын хөлгийн борт журналд хийсэн ажлаа зөв мөн тодорхой тайлагнаж гэрчилгээжүүлэх			
4	Агаарын хөлөгт ашигладаг тусгай багаж тоног, төхөөрөмж ашиглах			
5	Холбогдох хууль, дүрэм, журам мөрдөж ажиллах			
6	Агаарын хөлгийн шугамын сервис, үзлэг, үйлчилгээ хийх			
7	Агаарын хөлгийн хүндийн сервис, үзлэг үйлчилгээ хийх			
8	Агаарын хөлгийг дараагийн нислэгт бэлтгэн бэлэн байдлыг хангах			
9	Агаарын хөлгийн дутагдлын хяналт, хойшлуулсан ажлын жагсаалт, түүнийг арилгасан байдал			
10	ANM, агаарын хөлгийн Condition Monitoring хийж урьдчилсан техник үйлчилгээг хийх.			
Дундаж оноо				
ХОЁР. УДИРДЛАГА, ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ				
№	Үзүүлэлт	Үнэлгээ нийт (15 оноо)		
1	2	3		
1	Харилцаа, хандлага, ёс зүй			
2	Баг, хамтын ажиллагаа			
3	Олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцдог эсэх			
4	Хариуцлага хүлээх			
5	Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент			
6	Төлөвлөх, зохион байгуулах			
7	Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох			
8	Дүн шинжилгээ хийх			
Дундаж оноо				

ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (3-аас багагүй ажлаар үнэлнэ)	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Үнэлэх үзүүлэлт 1	
2	Үнэлэх үзүүлэлт 2	
3	Үнэлэх үзүүлэлт 3	
Дундаж оноо		
ДӨРӨВ. ААЧНАБА-ны ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (доорх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн үнэлгээний 10 онооноос хасч үнэлнэ.)	Үнэлгээ нийт (10 оноо)
1	2	3
1	ААЧНАБА-ын дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд засаж залруулаагүй бол.	
2	Заавар, дүрэм журмыг зөрчсөн бол.	
Дундаж оноо		
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		
1	Үндсэн ажлын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (60 хүртэлх оноо)	
2	Удирдлага, хамт олны үнэлгээ (15 хүртэлх оноо)	
3	Ур чадвар болон нэмэлт ажлын үнэлгээ (15 хүртэлх оноо)	
4	ААЧНАБА (10 хүртэлх оноо)	
Нийт үнэлгээ		

Ерөнхий үнэлгээ:	- 96 – 100 оноотой бол “А+ буюу Шилдэг” - 91 – 95 оноотой бол “А буюу Маш сайн” - 81 – 90 оноотой бол “В буюу Сайн” - 60 – 80 оноотой бол “С буюу Хангалттай” - 59 онооноос доош бол “F буюу Хангалтгүй”.
Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урамшуулах, хариуцлага тооцох гэх мэт. /-ний санал: Нэгжийн даргын тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж гэх мэт. /:	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Үнэлгээтэй танилцсан:

Ажилтан

(албан тушаал)

(гарын үсэг)

.....(огноо)

Хянасан:

АХЗҮ-ний Ерөнхий менежер

(гарын үсэг)

.....(огноо)



АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

НЭГ. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

1.1. Ажил үүргийг төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлохдоо ажил эхлэх, дуусах хугацааг харьцуулж тооцно. ИТА-наас хамаарахгүй шалтгаанаар хугацаа хоцорсон эсэхийг гүйцэтгэлийг хянаж, тогтооно.

Ажил үүрэг	Үнэлгээ өгөх	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн үнэлгээний хувь				Оноо (нийт 60)
Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажлын гүйцэтгэл	Нэгжийн дарга	Гүйцэтгэлийн түвшин	“Үр дүнгүй” ажлын 0-29 хувь хийгдсэн.	“Эрчимжүүлэх шаардлагатай” ажлын 30-59 хүртэл хувь хийгдсэн.	“Тодорхой үр дүнд хүрсэн” ажлын 60-89 хүртэл хувь хийгдсэн бол	“Төлөвлөсөн үр дүнд хүрсэн” ажлын 90-100 хүртэл хувь хийгдсэн бол	50 оноо
		Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал	Ажилтнаас хамаарах шалтгаанаар хугацаа хоцорсон.	Ажилтнаас хамаарах шалтгаанаар бага зэрэг хугацаа хоцорсон.	Ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар хугацаа хоцорсон.	Ажлыг төлөвлөсөн хугацаанд нь, эсхүл хугацаанаасаа өмнө гүйцэтгэсэн.	10 оноо

1.2. Ажил үүргийн гүйцэтгэлийн чанарыг үнэлэх арга зүй.

1.2.1. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ цагийн менежмент, хувийн зохион байгуулалт, бодит хугацаанд нийцүүлэн төлөвлөөгүй тохиолдолд тухайн ажлын гүйцэтгэлийг сул төлөвлөлт гэж үзэн үнэлгээг шатлал бууруулна.

1.2.2. Ажил үүргийн гүйцэтгэлийг цаг хугацаандаа тайлагнаагүй тохиолдолд тухайн ажил үүргийн гүйцэтгэлийн тайлангийн чанар муу гэж үзэн гүйцэтгэлийн түвшний үнэлгээг шатлал бууруулна.

1.2.3. Ажилтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгэлээ хугацаандаа тайлагнаагүй тохиолдолд нэгжийн дарга тухайн ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээнээс оноо хасаж тооцно.

1.2.4. Ажил үүргийн гүйцэтгэлийн түвшинг 0-100 хүртэл хувиар /50 оноо/ болон хугацаандаа гүйцэтгэсэн /10 оноо/ эсэхээс хамааран 0-100 хүртэл хувиар нийт 60 хүртэлх оноогоор үнэлнэ. Жишээ нь:

1.3. Ажил үүргийн гүйцэтгэлийг үнэлэх.

№	Ажил үүрэг	Гүйцэтгэлийн түвшин	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо
1	2	3	4	5
		50 оноо	10 оноо	60 оноо
ҮНДСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН БИЕЛЭЛТ (10-аас барагүй ажлаар үнэлнэ)				
1.	Үнэлэх үзүүлэлт 1	50	10	60
2.	Үнэлэх үзүүлэлт 2	42	7	49
3.	Үнэлэх үзүүлэлт 3	24	7	31
4.	Үнэлэх үзүүлэлт 4	50	10	60

5.	Үнэлэх үзүүлэлт 5	50	10	60
6.	Үнэлэх үзүүлэлт 6	50	10	60
7.	Үнэлэх үзүүлэлт 7	50	10	60
8.	Үнэлэх үзүүлэлт 8	50	10	60
БУСАД АЖЛЫН БИЕЛЭЛТ				
1.	Бусад ажил 1	42	7	49
2.	Бусад ажил 2	50	10	60
3.	Бусад ажил 3	24	7	31
4.	Бусад ажил 4	50	10	60
Дундаж оноо = $(60 + 49 + 31 + 60 + 60 + 60 + 60 + 60 + 49 + 60 + 31 + 60) / 12$ үзүүлэлт = 60 оноо				60 оноо

Дундаж онооны бодолт: 5-р баганын оноонуудыг хооронд нь нэмж нийлбэрийг олно. Дараа нь уг нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж дундаж оноог олно.

1.4. Бусад ажлын биелэлтийг үнэлэх арга зүй.

1.4.1. Нэгжийн дарга ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүрэгтэй агуулгын хувьд давхцахгүй, ажлын цар хүрээ, гүйцэтгэх цаг хугацааны хувьд дүйцэхүйц үүрэг даалгаврын гүйцэтгэлийг 1 ажил үүрэгтэй адилтган үнэлж болно.

1.4.2. Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүрэгтэй агуулгын хувьд давхцсан, эсхүл ажлын цар хүрээний хувьд бага, гүйцэтгэх цаг хугацааны хувьд богино үүрэг даалгаваруудын гүйцэтгэлийг нэгтгэн гүйцэтгэлийн дундаж хувийг тооцож, улирлын нэмэлт ажлын гүйцэтгэл гэж тодорхойлон 1 ажил үүргийн гүйцэтгэлтэй адилтган үнэлнэ.

ХОЁР. УДИРДЛАГА, ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ

2.1. Нэгжийн дарга өөрийн харьяалах нэгжийн ажилтны удирдлага, хамт олны үнэлгээг доорх аргачлалын дагуу үнэлэх ажлыг зохион байгуулах бөгөөд үнэлгээг ажилчдаас нууцаар санал авч, нэгтгэн тооцно.

№	Үзүүлэлт	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Харилцаа, хандлага, ёс зүй	15
2	Баг, хамтын ажиллагаа	7
3	Олон нийтийн ажилд идэвхи санаачлагатай оролцдог эсэх	10
4	Хариуцлага хүлээх	9
5	Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент	8
6	Төлөвлөх, зохион байгуулах	3
7	Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох	15
8	Дүн шинжилгээ хийх	15
Дундаж оноо $(15 + 7 + 10 + 9 + 8 + 3 + 15 + 15) / 8$ үзүүлэлт = 10.25 оноо		Оноо 10.25

Дундаж онооны бодолт: 3-р баганын оноонуудыг хооронд нь нэмж нийлбэрийг олно. Дараа нь уг нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж дундаж оноог олно.

ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Нэгжийн дарга өөрийн харьяалах нэгжийн ажилтны ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсанаас гадна нэмэлт ажил хийж гүйцэтгэх, байгууллагын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, сайжруулах, шинэ залуу инженер, техникийн ажилтныг сурган хөгжүүлэх /ментор хийх/, үр бүтээмжтэй ажиллах талаар шинийг санаачлах, ур чадвараараа бусдаас манлайлан ажиллаж байгааг харгалзан үнэлнэ.

ГУРАВ. УР ЧАДВАР БОЛОН НЭМЭЛТ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ		
№	Үзүүлэлт (3-аас багагүй ажлаар үнэлнэ)	Үнэлгээ нийт (15 оноо)
1	2	3
1	Сургалт хөгжлийн хөтөлбөр зохион байгуулж дагалдан сургах.	15
2	Агаарын хөлгийн дутагдал арилгах, оновчтой Troubleshooting хийх, засвар хийх	10
3	Төсөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах	10
4	Гуравдагч байгууллагын техник үйлчилгээнд ажиллах	15
5	Бусад 1	7
6	Бусад 2	8
7	Бусад 3	9
Дундаж оноо (15 + 10 + 10 + 15 + 7 + 8 + 9) / 7 үзүүлэлт = 10.57 оноо		10.57 оноо

Дундаж онооны бодолт: 3-р баганын оноонуудыг хооронд нь нэмж нийлбэрийг олно. Дараа нь уг нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж **дундаж оноог** олно. Хэрвээ 3-с бага үзүүлэлтээр дүгнэх бол бусад үзүүлэлтийг 0 оноогоор тооцож дундаж оноог олно. Жишээ нь: Зөвхөн 1 үзүүлэлтээр 15 оноо авсан бол Дундаж оноо $(15 + 0 + 0) / 3$ үзүүлэлт = 5 оноо.

ДӨРӨВ.АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЧАНАР НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮНЭЛГЭЭ

4.1. ААЧНАБА-ны дотоод аудитаар илэрсэн үл тохирлыг заасан хугацаанд засаж залруулаагүй болон заавар, дүрэм журмыг зөрчсөн эсэхийг харгалзан нийт үнэлгээнээс 10 хүртэлх оноог хасах байдлаар тооцож үнэлгээ өгнө.

ТАВ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Гүйцэтгэлийн үнэлгээнд ажилтан, нэгжийн дарга, АХЗҮ-ний Ерөнхий менежер нар гарын үсэг зурж баталгаажуулснаар тухайн ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үйл ажиллагаа дуусгавар болно.